


Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-д заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох баримт бичгээ бүрдүүлж, байгууллага тус бүрийн цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

**Тавигдах болзол, шаардлага:**

- Төрийн жинхэнэ албан тушаалд албан ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх;

**Бүрдүүлэх материал:**

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом), хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Нийгмийн даатгалын дэвтэр (хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас”-ны хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;

- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (e-mongolia-аас татан авах);

**Материал хүлээн авах:**

- Хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: Байгууллага бүрийн цахим хаяг, утасны дугаарыг байршуулсан болно.

**Мэдээлэл авах эх сурвалж:**

- https://hh.csc.gov.mn/?sector_id=02001048&offset=1&limit=10
- http://khovd.gov.mn/?page_id=17682
- https://e-mongolia.mn/home
- https://www.facebook.com/groups/1011120516311661\

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТООНЫ ЖАГСААЛТ

2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Ховд

| Д/д | Байгууллага | Дотоод нэгж | Ажлын байрны нэр | Албан тушаалын ангилал, зэрэглэл | Орон тоо | Боловсрол | Мэргэжил | Мэргэшил | Туршлага | Холбоо барих утасны дугаар | Мэйл хаяг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ГҮЙЦЭТГЭХ (ДЭС ТҮШМЭЛ) АЛБАН ТУШААЛ** | | | | | | | | | | | |
| 1 | Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар | Мал үржлийн алба | Малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл ТЗ-9 | 1 | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | Экологи, мал аж ахуй, ус судлал, хөрс судлал. | | Мэргэжлээрээ ажилласан бол давуу тал болно. | 99749827 | dtumenzaya.0327@gmail.com |
| 2 | Стандарт, хэмжил зүйн газар | Ховд аймаг дахь Стандарт хэмжил зүйн хэлтэс | Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн | Дэс түшмэл ТЗ-9 | 1 | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | - Хэмжилзүй;<br>- Менежмент ба удирдахуй (041301-041303);<br>- Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт (07);<br>- Мэдээлэл, харилцаа холбооны технологи (06);<br>- Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик (05). | | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | 95525506 | khovd@masm.gov.mn |
| 3 | Ховд аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар | - | Цахим технологи, мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл ТЗ-8 | 1 | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй | - Программ хангамж, программ хөгжүүлэлт ба шинжилгээ (0613);<br>- Өгөгдлийн сан, сүлжээний загварчлал ба удирдлага (0612);<br>- Компьютерын хэрэглээ (0611);<br>- Мэдээллийн болон харилцаа холбооны технологи ангилалд ороогүй хөтөлбөр (0619);<br>- Багш, мэдээлэл зүйн боловсрол (011403). | | | 99516129 | khovd@mecs.gov.mn |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Ховд аймгийн Хар нуур, Ховд голын сав газар | | Газар зүйн мэдээллийн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл ТЗ-9 | 1 | Бакалавр ба түүнээс дээш боловсрол-ын зэргэтэй байх | - Гидрогеологи инженер, геологи (053204);<br>- Геофизик (053205);<br>- Ус судлал (052202);<br>- Геодези (053201);<br>- Газар зүй (053202);<br>- Экологи (052101);<br>- Байгаль орчны зайнаас тандан судлал (053206);<br>- Газар зохион байгуулалт (газрын үнэлгээ, кадастр, төлөвлөлт) (073101);<br>- Усны нөөц экологи;<br>- Усны менежмент;<br>- Усны барилга байгууламжийн инженер; | | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | 90166265 | kharnuurkhovdgol@gmail.com |

**-oOo-**